# МОНГОЛ УЛСЫН
# ЦАХИМ ХӨГЖИЛ, ХАРИЛЦАА ХОЛБООНЫ
# САЙДЫН ТУШААЛ

2022 оны 07 сарын 06 өдөр Дугаар А/35 Улаанбаатар хот

Журам батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалт, Харилцаа холбооны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.14а дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Төрийн цахим мэдээллийн сан хариуцсан байгууллагаас үйлчилгээ үзүүлэх журам"-ыг хавсралт ёсоор баталсугай.

2. Энэ журмыг хэрэгжүүлж ажиллахыг “Үндэсний дата төв” УТҮГ /М.Баттулга/, журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг тус яамны Цахим хөгжлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Б.Билэгдэмбэрэл/-т тус тус үүрэг болгосугай.

3. Энэ журам батлагдсантай холбогдуулан Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын /хуучнаар/ даргын 2020 оны А/39 дүгээр тушаалаар батлагдсан "Үйлчилгээний журам батлах тухай" журмыг хүчингүй болгосугай.

БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ САЙД
БӨГӨӨД ЦАХИМ ХӨГЖИЛ, ХАРИЛЦАА
ХОЛБООНЫ САЙДЫН
ҮҮРЭГ ХАРИУЦАГЧ Л.ЭНХ-АМГАЛАН

993676

Цахим хөгжил, харилцаа холбооны
сайдын 2022 оны 07 дугаар сарын
06 -ны өдрийн А/135 дугаар
тушаалын хавсралт

# ТӨРИЙН ЦАХИМ МЭДЭЭЛЛИЙН САН ХАРИУЦСАН БАЙГУУЛЛАГААС ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ЖУРАМ

## Нэг.Ерөнхий зүйл

1.1.Энэ журмын зорилго нь төрийн цахим мэдээллийн сан хариуцсан байгууллагаас хүн, хуулийн этгээдэд үзүүлэх үйлчилгээг тодорхойлох, үйлчилгээг хүргэхтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулахад оршино.

1.2.Төрийн цахим мэдээллийн сан хариуцсан байгууллага нь “Үндэсний дата төв” УТҮГ (цаашид “Үндэсний дата төв” гэх) байна.

1.3.Энэ журмаар зохицуулаагүй бусад харилцааг Үндэсний дата төв болон хүн, хуулийн этгээд хооронд байгуулсан үйлчилгээний гэрээгээр нарийвчлан зохицуулж болно.

1.4.Үндэсний дата төв дараах үйлчилгээг үзүүлнэ:

1.4.1.төрийн байгууллагад домэйн нэр олгох;

1.4.2.төрийн байгууллагын цахим хуудас байршуулах;

1.4.3.төрийн байгууллагын цахим шуудангийн хаяг олгох;

1.4.4.төрийн байгууллагын мэдээллийн сан байршуулах;

1.4.5.төрийн үйлчилгээний цахим (ТҮЦ) машинаар төрийн байгууллага, хуулийн этгээдэд үзүүлэх үйлчилгээ;

1.4.6.төрийн байгууллагын зохиомол сервер түрээсийн үйлчилгээ;

1.4.7.зогсуур түрээсийн үйлчилгээ;

1.4.8.”Төрийн мэдээлэл солилцооны систем”-д холбох үйлчилгээ;

1.4.9.“Танилт нэвтрэлтийн систем”-д холбогдох үйлчилгээ;

1.4.10.“Мэдэгдэл хүргэх систем”-ийн үйлчилгээ;

1.4.11.Интернэтийн дотоод харилцан холболтын үйлчилгээ.

1.5.Энэ журмын 1.4.8, 1.4.9, 1.4.10 –д заасан үйлчилгээг Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 18.10-д заасан журмын дагуу зохицуулна.

1.6.Энэ журмын 1.4.8, 1.4.9, 1.4.10 –д зааснаас бусад үйлчилгээний техникийн нөхцөл, үйлчилгээний гэрээний загварыг Үндэсний дата төв-ийн захирал батална.

1.7.Үйлчилгээ авах талаар хүн, хуулийн этгээдээс гаргасан хүсэлтийг ажлын 5 өдрийн дотор судалж, холбогдох хүсэлтийн хариуг өгнө.

1.8.Хүн, хуулийн этгээд нь энэ журмын 1.3-т заасан үйлчилгээг авах, авснаас хойш Үндэсний дата төвийн шаардсанаар мэдээллийн аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ хийнэ.

1.9.Үндэсний дата төв нь төлөвлөгөөт техникийн үзлэгээс шалтгаалан үйлчилгээ тодорхой хугацаагаар зогсох тохиолдолд энэ талаар хүн, хуулийн этгээдэд цахим хэлбэрээр эсхүл албан бичгээр 48 цагийн өмнө мэдэгдэнэ.